



ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 1/18

Улаанбаатар хот

Ёс зүйн хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 2.1 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоол "Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоох, дүгнэлт гаргах эрх бүхий "Ёс зүйн хороо"-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Ш.Чинбат

Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

Н.Мандуул

Залуучуудын хөгжлийн бодлого, үндэсний хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн

Б.Уянга

Дотоод үйл ажиллагааны эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Санжид

Зорилтот гэр бүлийн хөгжил хариуцсан мэргэжилтэн

О.Сэлэнгэ

Хүүхдийн хөгжил, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

А.Майжаргал

Мэдээллийн сан, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичиг:

Э.Баяржаргал

Хүний нөөц, судалгаа, мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн

0000286

2. Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулах, хэрэгжилтийг хангах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Ёс зүйн хороо /Ш.Чинбат/-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Халиун/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.АЛТАНСҮХ